



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 94

Мандалговь

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 38,792,050 /гучин найман сая долоон зуун ерэн хоёр мянга тавь/ төгрөгийн балансын үнэтэй, 19,396,025 /арван есөн сая гурван зуун ерэн зургаан мянга хорин тавь/ төгрөгийн элэгдэл бүхий 2015 онд ашиглалтанд орсон 37-26 ДУА улсын дугаартай УАЗ Патриот маркын автомашиныг Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг, Сайнцагаан сумын ИТХ-ын дарга Б.Өлзийбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 12-р сарын 15-ны өдрийн дотор багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

